



Дулаан шийдэл төсөл



ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

2021 оны 4-ээр улирлын үйл ажиллагааны хураангуй

Дулаан шийдэл төслийн хөндлөнгийн хорооны эрхэм гишүүд ээ,

"Дулаан шийдэл" төсөл нь 2018 оноос хойш Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгаснаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна. Төслийн санхүүжүүлэгч байгууллагаар Европын холбооны Свитч-Эшиа хөтөлбөр, Абби Пиер сан, Чехийн хөгжлийн агентлаг болон Францийн хөгжлийн агентлаг ажиллаж байна. Төслийг Жэрэс ОУТББ, ШУТИС-ын дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ болон Пипл ин Нийд ОУТББ хамтран хэрэгжүүлж байна.

Ингээд та бүхэн төслийн 4 дүгээр улирлын онцлох үйл ажиллагаатай танилцана уу.

4 дүгээр улирлын онцлох мэдээ



6,723,792

Цахим болон биет маркетинг, сурталчилгаагаар хүрсэн хүний тоо
*давтагдсан тоогоор



893

2021 онд авсан Техникийн үнэлгээний
захиалгын тоо



40

Идэвхтэй Эрчим хүчний
зөвлөхүүд болон Бригад



12,760

2021 онд дуудлага төвөөр холбогдсон
хэрэглэгчдийн тоо



www.dulaalga.mn

Төслийн шинэчлэгдсэн вэбсайт
ашиглалтанд орж хэрэглэгчдэд
хүрлээ



Олон нийтийн санал гомдлын механизм

Олон нийтийн санал гомдлын механизмын бичиг баримт бэлэн болж,
санал гомдол шийдвэрлэх хороо байгуулагдлаа




Дулаалгын ажлын гарын авлага, чанарын хяналтын актууд

Дулаалгын ажлын гарын авлага, актууд хэвлэгдэж олон нийтэд хүрэв



Жендер хамгаалал

"Жендер ба хамгааллын хэрэгслүүд"
сэдэвт сургалт орлоо



Маркетинг, сурталчилгаа

- 10 дугаар сард Дээврийн дулаалгын 20%-ийн урамшуулал зарласантай холбоотой доорх идэвхжүүлэлтүүд хийгдлээ:
 - Зарлалын самбаруудыг гэр хорооллын замын уулзварууд болон 4 чиглэлийн автобусанд байршууллаа. Үр дүнд нь давтагдсан тоогоор нийт 650,000 хүнд хүрэв.
 - ФМ радио болон ТВ-ээр зар сурталчилгааг цацлаа. Үр дүнд нь нийт давтагдсан тоогоор 206,000 хүнд хүрсэн байна.
- 11-ээр сард Ажлын хөлсний 30%-ийн хямдрал зарласантай холбоотой Улаанбаатар хотын төвийн автобусны буудал болон мэдээллийн 18 самбар, дижитал дэлгэцүүдээр ногоон зээл болон төслийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллүүдийг байршууллаа. Үр дүнд нь давтагдсан тоогоор нийт 5,769,792 хүнд хүрсэн байна.
- 12-аар сард +5 дээврийн урамшууллыг зарлаж онлайн маркетинг хийлээ. Тус урамшууллаар дээврийн дулаалгын худалдан авалт хийсэн тохиолдолд, 5 см-ийн нэмэлт дулаалгыг урамшуулал болгон өглөө. Үр дүнд нь нийт 14 дулаалгын захиалгыг гүйцэтгэв.
- Мөн маркетингийн урамшууллын талаар мессеж зар илгээн 98,000 хүнд хүргэв.

Үйл ажиллагаа

- Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар болон Хас банкнаас хамтран зохион байгуулсан “ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА” арга хэмжээнд оролцож Баянзүрх дүүргийн 60, Сонгино-хайрхан дүүргийн 90 гаруй иргэдэд дулаалгын ач холбогдол, зарлагдаж буй урамшуулал, төсөлтэй хэрхэн хамтран ажиллах талаар болон хөнгөлөлттэй ногоон зээлийн боломжуудын талаар мэдээлэл өгөв.
- Төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаануудын дараах баримт бичиг бүрдүүлэлт болон хяналтын хугацаанд мөрдөх журмыг батлан 11 сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэллээ.
- Дулаан шийдэл төсөл нь www.dulaalga.mn вэб сайтаа шинэчлэн сайжруулж 2021 оны 11 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн ба уг системээр дамжуулан хэрэглэгч, санхүүгийн байгууллага, дулаалгын сургагдсан бригадууд, эрчим хүчний зөвлөхүүд болон төслийн ажилтнууд мэдээ мэдээллээ нэг доороос авах, хянах боломж бүрдсэн. Мөн 12 дугаар сараас эхлэн вэб системээ мессеж про үйлчилгээтэй холбосноор бригадын ахлагч, эрчим хүчний зөвлөхүүд, хэрэглэгчид холбогдох мэдээллээ мессежээр хүлээн авдаг боллоо.
- Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо)-ноос зохион байгуулсан “Монголын Тогтвортой Санхүүгийн Форум 2021” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Эрчим хүчний хэмнэлттэй сууцны санхүүжилт” панел хэлэлцүүлэгт панелистаар оролцов.

Гарын доорх материалыг ашиглан хялбар, хямд аргаар байшингаа дулаалах "Хялбар шийдэл" аяны 2 дахь үе шат хэрэгжлээ. Иргэд, олон нийтийн оролцоотой хэрэгжиж буй тус аяны гол зорилго нь дулаалгын ач холбогдлын талаарх ойлголтыг түгээх, дулаалгын талаар суурь мэдлэг олгож цаашлаад агаарын бохирдлыг бууруулах юм.

4 дүгээр улирлын онцлох мэдээлэл



750

Айл хялбар дулаалгын аргуудыг гэртээ хэрэгжүүлж,
байшингаа дулаалав




13



170

Нийт 13 удаа сургалт орж, 170 айл өрхөд мэдээлэл
түгээлээ



100

Хаалга, цонх дулаалгын материалын
100 багц бэлдэж түгээв

160

Аяны 2-аар шатанд нийт 160 айлын
дээврийг 5см-ийн зузаантай эрдэс
хөвөнгөөр дулаалж өглөө



5,300

Фэйсбүүк группын гишүүдийн тоо

- “Хялбар шийдэл” аяны олон нийтэд зориулсан сургалтыг Сонгинохайрхан дүүргийн 8 хороонд (41, 11, 24, 25, 42, 4, 34, 35), Сүхбаатар дүүргийн 5 хороонд (13, 15, 16, 17, 18) зохион байгуулж нийт 170 гаруй өрх гарын доорх материал ашиглан хялбар аргаар байшингаа дулаалах талаар ойлголттой болов. Сургалтаар дулаан алдагдлын тухай суурь мэдээлэл өгөхийн зэрэгцээ дулаалга хийснээр бий болох эрүүл мэнд, эдийн засгийн давуу талуудыг таниулав.
- “Хялбар шийдэл” аянаас Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүдэд зохион байгуулсан олон нийтэд зориулсан сургалтад суусан иргэд хялбар дулаалга хийх аргыг хөршүүддээ зааж түгээн, дулаалга хийхэд уриалав. Хөршөөсөө мэдээлэл авсан нийт 750 айл хялбар аргуудыг гэртээ хэрэгжүүлж, байшингаа дулаалан агаарын бохирдолтой тэмцэхэд хувь нэмрээ орууллаа.
- Хялбар аргаар дулаалга хийх талаар сургалтад сууж, ойлголт аваад зогсохгүй өөрийн хөрш, хүрээлэлдээ агаарын бохирдолтой тэмцэхэд чухал ач холбогдолтой мэдээллийг түгээж, аянтай хамтарч ажилласан өрхийн дээврийг 5см зузаан материалаар дулаалж өгч урамшуулав. Аяны хоёрдугаар шатанд 160 айлын дээврийг дулаалсан бөгөөд аяны хэмжээнд нийт 260 айлын дээврийг дулаалж өгсөн үзүүлэлттэй байна.



Өвлийн хэмжилт

"Өвлийн хэмжилт"-ийн үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг бөгөөд энэ жил 4 дэх удаагаа амжилттай зохион байгуулж байна. Энэ жилийн өвлийн хэмжилтэд гэр хороололд хувийн сууц бүхий 44 өрх оролцож байгаа бөгөөд технологийн дагуу төслөөр бүтэн дулаалуулсан, "Хялбар шийдэл" аяны хүрээнд дээврээ дулаалуулсан, өөрсдөө дулаалсан, болон огт дулаалгагүй гэсэн дөрвөн төрлийн дулаалгын нөхцөл бүхий сууцуудыг сонгон авч хэмжилтэд оролцуулсан.


- Өвлийн хэмжилтээс хүлээгдэж буй үр дүн нь:
- Түлшний хэрэглээ
- Халаалтын эрчим хүчний хэрэгцээ
- Хүлэмжийн хийн ялгарал
- Дулааны тав тух
- Дотоод орчны агаарын чанар
- Нийгэмд үзүүлэх нөлөөллийн асуумж судалгаа

Шилэн гонх туршилт

Шилэн гонх нь нарны дулааны коллектортой төстэй ажиллагаатай ба өдрийн цагт нарны дулааны энергиэр дотор агаараа халааж, барилга руу дулаанаа нэвтрүүлнэ. Энэ нь дулаан алдагдлыг багасган, өмнө ханатай залгаа өрөөг илүү дулаан тав тухтай болгохоос гадна, дотроо дулаахан нэмэлт зай талбай үүсгэнэ.

Шилэн гонхны сайжруулсан туршилтын бэлтгэл ажлууд хийгдэж байна

- Өрх сонгох:
 - Шалгуур үзүүлэлт: 14
 - Хүсэлтээ ирүүлсэн өрхийн тоо: 294
 - Сонгосон өрхийн тоо: 1
- Зохиомжлол гаргах:
 - Туршилтын загварт үндэслэсэн сайжруулалт
 - Тооцоо, симуляци



Дулаалгын гарын авлага, материал


- Барилгын дулаалгын чанарын хяналтын тогтолцоо сэдэвт гарын авлага болон актуудыг танилцуулах өдөрлөгийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр зохион байгуулав.
- Дулаалгын ажлын гарын авлага болон барилгын ажлын чанарын хяналтын актуудыг хэвлүүлж хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд болон танилцуулах үйл ажиллагааны оролцогчдод түгээв.

Сургалт

- 6 дугаар ээлжийн бригадууд загвар барилга угсарч гадна хаших бүтээцүүдийн сургалтын үеэр олж авсан мэдлэгээ баталгах дадлага ажил хийв.
- 2021 оны 12 сарын 13-14-ны өдрүүдэд 13 Эрчим хүчний зөвлөхүүдэд дулааны камерын хэмжилт хийх талаар практик сургалт явуулав.
- Цонх суурилуулалт ба агаар сэлгэлтийн системийн суурилуулалтын тухай зааварчилгаа өгөх цуврал видео хийв.

Үйл ажиллагаа

- Эрчим хүчний зөвлөхүүдийн бөглөж ирүүлсэн дулаалгын ажлын чанарын хяналтын актыг хянаж баталгаажуулж байна.
- Веранда буюу шилэн гонхны загвар, хийцлэлийг эцэслэж, суурилуулах айл өрхийг сонгон шалгаруулав.
- Өвлийн хэмжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж зохион байгуулалтын ажлыг эцэслэв. Энэ жил хэмжилтэнд 44 өрх хамрагдаж байна. Мөн дулааны тав тухыг нэмэлтээр хэмжих туршилт хийгдэнэ.



Үйл ажиллагаа

- 6-аар ээлжийн бригадын элсэлтийг авч 16 хүнийг төсөлд сонгон шалгаруулав.
- Дулаан шийдэл төслийн шинэчлэгдсэн веб системийг танилцуулж ашиглах сургалт-дадлагыг нийтдээ 2 удаа буюу 10 дугаар сарын 01 болон 28-ны өдрүүдэд МБҮА ТББ нь Пипл Ин Нийд ОУ-ын ТББ-ын, БЭХХТ, Жэрэс ОУ-ын ТББ зэрэгтэй хамтран зохион байгуулж, нийтдээ Төслийн 26 Бригадын ахлагч нарыг хамруулав. Төслийн Бригадуудын мэдээллийг цахим систем рүү шилжүүлэн ажиллуулж байна.
- "Санал гомдол шийдвэрлэх болон барагдуулах журам"-ыг шинэчлэн баталж 2021 оны 11 дүгээр сараас эхлэн мөрдөж ажилласан бөгөөд төслийн бригадын ахлагч нарт танилцуулав.
- 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр МБҮА ТББ-ын Төслийн баг нь шинээр ЭХЗ-өөр ажиллах болзол хангасан **V-р ээлжийн 6 Бригадын ахлагчдад ЭХЗ-ийн багцыг гардуулан өгөв.** Арга хэмжээний хөтөлбөрийн дагуу МБҮА ТББ-ын Төслийн багын гишүүд нь шинэ Бригадын ахлагч/ЭХЗ-д төсөлтэй хамтран ажиллах дэлгэрэнгүй зааварчилгаа, мэдээлэл болон зөвлөмжийг танилцуулав.
- 2021 оны 10 дугаар сарын эхний долоо хоногт МБҮА ТББ нь "Дулаан шийдэл" төслийн хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлж, Монгол Улсын Улаанбаатар хотын **Чингэлтэй дүүрэг дэх өөрийн Салбарыг** шинээр нээв. Үүнтэй холбогдуулан Салбарын гэрчилгээ, тамга тэмдгийг УБЕГ-с албан ёсоор бүртгэлжүүлэн хүлээн авлаа.



САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ГЭРЧИЛГЭЭ
000006781

Салбар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй. Эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу ажиллагаагаа нэвүүлнэ.

8002541
/Регистрийн дугаар/

9071001143
/Дулаан хэрэгсэл дугаар/

Монголын барилгын үндэсний ассоциаци НҮТББ
Чингэлтэй дүүрэг дэх салбар
/Хуулийн этгээдийн салбарын нэр/

05
/Эрх бүхий байгууллагын газрын шийдвэрийн дүгээр/

2021.09.27
/тн, сар, өдөр/

6412
/Холбооны салбарын өмчлөх эрх зүйн төлөвт оршиж буйруулах, барилгын монголчлолын үйлдвэрлэлийн хэрэгсэл, цонх, байршилтай төхөөрөлдөх нөхцөлүүдийг бэлтгэх үзүүлэлт/

Улаанбаатар, Чингэлтэй, 5-р хороо, самбуугийн гудамж, 24, МН Тауэр, 8 дэлхарт, 805 тоот
Утас: 99998028
/Салбарын албан ёсны хаяг, утас/

Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХУУЛЬН ЭТГЭЭДИЙН ХУСН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/Бүртгэлийн байгууллагын нэр/

УЛСЫН
БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ
ГАЗАР
/Тамга тэмдэг/

2021 оны 10-р сарын 04



Пипл ин нийд ОУТББ

Үйл ажиллагаа

- Олон нийтийн санал гомдлын механизмын баримт бичгүүд бэлэн болж төслийн Олон нийтийн санал гомдлыг шийдвэрлэх хороо байгуулагдлаа.
- ПИН-ийн Жендерийн мэргэжилтэн төслийн хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын ажилтнуудад "Жендер ба хамгааллын арга хэрэгслүүд" сэдвээр бригадууд жендерийн сэдвээр сургалт явууллаа.
- Төслийн вэбсайтын хэрэглэгчдэд зориулсан хэсэг бэлэн боллоо. Бригадын ахлагч нарт зориулсан вэбсайтын backend сургалт зохион байгуулагдсан бөгөөд 11 сараас эхлэн бригадын ахлагч нар байр сууцны үнэлгээ, дулаалах ажлын явц, дүгнэлтүүдийг вэбсайт ашиглан солилцох боломжтой боллоо.
- Маркетингийн хүрээнд Одзаяагын "Бэлэг" нэвтрүүлэгт оролцон 10 айлд дээврийн дулаалга хийж өгөв.
- Төслийн New Media Group-тэй хамтран хийсэн PR аяны 3 дахь үе шат амжилттай хэрэгжиж дууслаа. Үр дүнд нь Фэйсбүүк хуудасны дагагчдын тоо 14,613-т хүрч контентуудын тоо нийт 1,091,750 хүнд хүрсэн байна.



Хэрэгжүүлэгч байгууллагуудын тухай



Жэрэс ОУТББ нь Европ, Африк, Ази тивд 40 гаруй жил ажиллаж буй эрчим хүч, тогтвортой хөгжлийн чиглэлээр мэргэшсэн олон улсын төрийн бус байгууллага бөгөөд ард иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулахад хувь нэмрээ оруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах үйл ажиллагаа явуулдаг. Жэрэс ОУТББ нь 2010 оноос эхлэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Орон нутгийн болон хот суурин газрын амьдрах орчинг сайжруулж, иргэдийн даван туулах чадварыг нэмэгдүүлснээр шилжин суурьшигчдын тоог бууруулж, түүнээс үүдэн гарах сөрөг үр дагаврыг багасгаж байна.



mongolia@geres.eu



[Geres Mongolia](https://www.facebook.com/GeresMongolia)



7505-2000



ШУТИС-ийн Барилга Архитектурын Сургуулийн харьяа Барилгын Эрчим Хүч Хэмнэлтийн Төв дэргэдээ “Барилгын Дулааны Физик Агаарын Судалгаа”-ны итгэмжлэгдсэн лабораторитой, барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй техник технологийг нэвтрүүлэх зорилготойгоор туршилт, судалгаа, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.



beecmongolia@gmail.com



[BEEC](https://www.facebook.com/BEEC)



9903-3553



Монголын үндэсний барилгын ассоциаци нь Монгол Улсын томоохон үндэсний бүтээн байгуулагчдыг эгнээндээ нэгтгэсэн, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэдэг, барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулж буй хамгийн том нэгдэл болох салбарын мэргэжлийн, манлайлагч байгууллага юм. Ассоциаци нь барилгын салбарт бодлого, эрх зүй, эдийн засгийн шинэчлэлийг хийхэд нөлөөлөх замаар төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, үндэсний хэмжээнд гишүүн байгууллагуудынхаа ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалж төлөөлөх, барилгын салбарын бичилжиг-дунд (БЖД) бизнес эрхлэгчдийг дэмжин ажилладаг байна.



geres_pc@mnca.mn



[Mnca Mbua](https://www.facebook.com/MncaMbua)



7011-1515



Пипл ин Нийд ОУТББ нь хүний амь нас, аюулгүй байдлыг хамгаалж, олон нийтийг чадавхжуулж, тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор 2011 оноос эхлэн Монголд тогтмол үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өдгөө онцгой байдлын тусламжаас гадна тогтвортой амьжиргааг дэмжих, хоршоо, иргэний нийгмийн байгууллагууд ба төрийн албаныхны чадавхыг нэмэгдүүлэх, дээд боловсролыг дэмжих, хүрээлэн буй орчныг хамгаалах болон агаарын бохирдлын тухай иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.



info.mongolia@peopleinneed.cz



[People in Need Mongolia](https://www.facebook.com/PeopleinNeedMongolia)



7011-1501